

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

ИРГЭДИЙН УЛС ТӨРИЙН БОЛОВСРОЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХЭД ОНМХ-ИЙН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Б.Наранбаатар*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

Түлхүүр үг: олон нийтийн мэдээлэл харилцаа, улс төрийн боловсрол, ОНМХ-ийн систем, сэтгүүл зүйн нийг-мийн хариуцлага, ардчилал, сэтгүүл зүйн контент, улс төр.

Монгол Улс ардчилсан тогтолцоо, чөлөөт эдийн засгийн харилцаанд шилжээд 30 шахам жилийн нүүр үзлээ. Нэг улс орны түүхэн замналын хувьд өчүүхэн цаг хугацаа боловч, энэ цаг үед амьдарч буй иргэдийн амьдралын тухайд бага биш мөчлөг. Улс төрийн олон үзэл баримтлалын дундаас бодлогын сонголтыг иргэд хийж, тайван замаар засгийн эрхийг шилжүүлдэгт энэхүү ардчиллын үнэ цэн нь оршдог. 1990-ээд онд борооны дараах мөөг шиг гарч ирсэн олон нам дор бүрнээ өөрийн үзэл баримтлал /идеологи/-ыг иргэдэд таниулах ажлыг эрчимтэй эхлүүлж байв.

Нийгэм, эдийн засгийн бодлого, боловсрол, эрүүл мэнд, нийгэм хамгааллын салбарт тухайн идеологи дээр суурилсан хандлагын ялгаа юунд орших тухайд нийгэмд хэлэлцүүлэг өрнөж, энэ нь ч ардчилсан шилжилтийн эхний жилүүдэд олон нийтэд улс төрийн боловсролыг чамгүй олгосон юм. Үүнээс хойш даруй долоон удаа ардчилсан сонгуулиар УИХ, орон нутгийн төлөөлөгчдийн хурлаа бүрдүүлж, мөн удаа Ерөнхийлөгчийн

сонгуулиар Төрийн тэргүүнээ тодруулан, парламентийн засаглалтай ардчилсан тогтолцооны хувьд багагүй туршлага хуримтлуулсан. Гэтэл энэ хугацаанд парламентад ээлжлэн давамгайлж, Засгийн газраа дангаараа болон хамтран байгуулж ирсэн хоёр нам, тэдний араас “суудал” зулгаадаг нэг, хоёр улс төрийн хүчин өдгөө идеологийн өрсөлдөөн, мэтгэлцээн өрнүүлэхээ больжээ. Үр дүнд нь иргэдийн улс төрийн соёл, боловсролын асуудал гээгдэж хоцорчээ. Сонгуулийн үйл явц, улс төрийн үйл явдлын талаарх олон нийтийн мэдлэг, төсөөлөл зонхилогч хоёр намынхны “гал тогооны” хэрүүл, популист амлалт, мэдэгдлүүдээр хэмжигдэх болов. Хэвлэл мэдээллийнхний хувьд ч сонгогчийн боловсрол, улс төрийн үзэл баримтлалын ялгаа, мөрийн хөтөлбөр, бодлогын мэтгэлцээнд анхаарал хандуулах нь суларсаар, сүүлдээ энгийн иргэдтэй адил бидон, шанаганд хууртдаг, УИХ-ын гишүүдээс санаачилсан хууль нэхэх бус, тойрогтоо хэдэн жорлон, хэдэн км зам тавьсныг нь асуудаг түвшинд очсон байна.

2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үеийн мэдээлэл харилцааны тухайд доктор Б.Болд-Эрдэнэ дүгнэн бичихдээ “Улс төрийн үнэлэмж, соёл талаасаа 2017 оны сонгууль нийгэм, эдийн засгийн хөгжил, бодлогын талаарх мөрийн хөтөлбөр, үзэл санааны шударга өрсөлдөөн, Ерөнхийлөгчийн албан үүрэг, эрх мэдэл болох үндэсний эв нэгдэл, гадаад бодлого, шүүхийн тогтолцоо, батлан хамгаалах, тусгаар тогнолын тухай бодит, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх мэтгэлцээн, санал ҮГҮЙ, хар PR мэдээллийн түүхэн жишээ, үйл явдал боллоо” хэмээжээ¹.

Орчин үеийн Монголын ардчилсан тогтолцооны замналд чухлаар тавигдах нэгэн асуудал бол иргэний нийгмийн төлөвшил, оролцоог хангах явдал юм. Харин энэ нь нийгмийн гишүүн бүрийн улс төрийн соёл, боловсролын түвшинг зохих хэм хэмжээнд хүргэхгүйгээр боломжгүй зүйл. УИХ, Засгийн газар, түүний харьяа төрийн субъектуудын нийгэм-улс төрийн амьдралд, эдийн засгийн нөхцөл байдалд чухам ямар үүрэг оролцоотой байдаг, байх ёстой, байгаа вэ гэдгийг иргэд зөв баримжаатайгаар мэдэх, ойлгох, мэдээллийг хүлээн авах, шүүн тунгаах нь чухамдаа улс төрийн боловсролыг илтгэх үзүүлэлт юм. Энгийн жишээгээр тайлбарлавал, УИХ-ын гишүүн хүн сонгогчдынхоо эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, түүнд чиглэсэн хууль, хуулийн төсөл санаачлан боловсруулах үүрэгтэй болохоос сонгогчдод бэлэг өгөх, тойрогтоо зам харгуй, дэд бүтцийн асуудал шийдэх чиг үүрэггүй гэдгийг иргэд ухамсарлах нь наад захын улс төрийн соёл юм.

Иргэдийн улс төрийн боловсролын түвшин дорой байгаа нь дараах

гурван зүйлээр түгээмэл илэрч байна. Үүнд:

- *Төрийн субъектүүдийн талаар ойлголт муу.* Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ, төрийн байгууллагууд, төрийн албан хаагчид нь хуулиар хүлээсэн ямар үүрэг, эрх мэдэлтэйг үл мэднэ, үл ойлгоно гэдэг бол популист амлалт, мэдэгдэлд хялбар автах, үнэмших суурь болж байна. УИХ гишүүнд нэр дэвшиж буй хүн “Авлигатай тэмцэнэ, Эдийн засгийг сэргээнэ” гэж зарлах нь утгаа утгагүй зүйл гэдгийг сонгогчид мэдэж байх ёстой. Иргэдийн ядмаг ойлголтыг хэвлэл мэдээлэл олон жил “дэвэргэн” хөөрөгдсний дүнд сонгогчид тойргийнхоо гишүүнээс гарын бэлэг, мөнгөн тэтгэлэг “нэхдэг”, түүгээрээ ажлын үр дүнг хэмждэг болов.
- *Төрийн үйл ажиллагааг хийсвэрээр төсөөлдөг.* Ардчилсан тогтолцоонд төрийн албан хаагч, өндөр албан тушаалтан бол иргэдэд үйлчилж буй этгээд. Гэтэл үл мэдэх хандлагаас үүдсэн хардалт нь иргэд, ОНМХ-үүдэд төрийн тухай нийтлэг, сөрөг стереотипийг бүрдүүлсэн. Энэ нь иргэдийн үзэл бодол, хэвлэл мэдээллийн нийтлэл, нэвтрүүлэг дэх “эзэн биегүй буруутгал”-аар илэрнэ.
- *Иргэд хуулиар олгогдсон эрх мэдэл, оролцооны боломжоо ашигладаггүй.* МУ-ын төсвийн нэгдсэн хууль дахь “Орон нутгийн хөгжлийн сан” бүрдүүлэх тухай заалт, ЗГ-ын тогтоол, “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл олж авах эрхийн тухай”, “Шилэн дансны тухай” гэх мэт иргэд, олон нийтийн оролцоо, хяналтыг баталгаажуулсан олон хууль бий. Тэдгээрийн хэрэгжилтэнд мониторинг хийхэд үр

дүн ихэвчлэн хангалтгүй гардаг. Хорооноос төсвийн санал авахад дүүрэгтээ зам, хүүхдийн талбай засах саналыг иргэн өөрөө гаргаад, төсөв бүрдүүлэлт, зарцуулалтыг хянаад, эсвэл өөрөө оролцож гүйцэтгэх ч боломж бий. Гэтэл “манай гишүүн муу болохоор, зам засахгүй байна” хэмээн шүүмжлэх нь элбэг.

Иргэний нийгмийн зөв хөгжил, олон нийтийн улс төрийн соёл, боловсролын зохист төлөвшилд ОНМХ-үүд чухал үүрэгтэйг онцолсон онол, практикийн бүтээл, судалгааны үр дүн олон бий. Ардчилсан тогтолцоонд хэвлэл мэдээллийн олон ургальч төлөв, санхүүгийн бие даасан байдал, мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээ зэрэг нь нийгмийн бүлэг тус бүрийн эрх ашгийг илэрхийлэх, хамгаалах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бодитойгоор хэрэгжүүлэх үндэс болох ёстой.

ОНМХ-ийн систем нь иргэний нийгмийн салшгүй нэг хэсэг, нөлөө бүхий институт мөн бөгөөд радио, телевиз, сонин, сэтгүүлүүд улс орны аж байдлын талаар олон нийтийн санаа бодлыг төлөвшүүлж, түүнд нөлөөлж байдаг. Тэрхүү санаа бодол /public opinion/ хэр бодитой, объектив байх нь систем дэх хэвлэл мэдээллийн олон ургальч байдлаас шууд хамаарна. Өөрөөр хэлбэл, нийгэм олон талт байр суурь, эрх ашиг ОНМХ-ээр дамжин нийтийн хүртээл болж, эрх баригчдад хүрч байх учиртай.

Хүн амын интернет, нийгмийн сүлжээний хэрэглээ өсөн нэмэгдэж, үйл явдал, баримтын мэдээний түвшинд уламжлалт сэтгүүл зүй давуу байдлаа алдаж эхэлснийг олон судлаач онцлох болсон. Мэдээлэл харилцааны хувьслын энэ торгон үед

мэргэжлийн сэтгүүл зүйн хариуцлага, ёс зүй, нийтлэл, нэвтрүүлгийн чанарын шаардлага шинэ түвшинд тавигдаж байна. Тэр хэрээр, уламжлалт мэдээллийн хэрэгслийн нөлөө буурах бус, харин ч өсөн нэмэгдэж буй юм. Учир нь хувь хүний эрх ашигт нийцсэн мэдээлэл /ФБ, Твиттер, зорилтот социал акаунт г.м./ олон нийтэд хүрэх арга хэрэгсэлтэй болсноор, мэдээ, мэдээллийн орон зайд иргэд, олон нийтийн эрх ашиг, түүнийг илэрхийлэх, “олж харах”, хамгаалах хэрэгцээ улам бүр тодорч байна.

Өнөө үед ОНМХ-ийн улс төрийн процесс дэх чиг үүрэг бол нэгдүгээрт, иргэдийн “мэдэх эрх”-д үйлчлэх, хоёрдугаарт, олон нийтийн санаа бодлыг нэгтгэх, төлөвшүүлэх, гуравдугаарт, иргэдийн улс төрийн боловсрол, нийгэмшилд түлхэц болох, дөрөвдүгээрт, нийгмийн бүлгүүдийн эрх ашгийг илэрхийлэх, төр, нутгийн удирдлагын байгууллагын үйл ажиллагааг ил тод, хяналттай байлгах² зэрэг болно.

Монгол Улсын хэвлэл мэдээллийн тогтолцооны чанар, чадамж, ёс зүйн тухайд эргэлзээ, шүүмж багагүй бий. Зарим хэсэг нь үндэслэлтэй. Гэвч нийгмийн зүгээс уламжлалт мэдээллийн хэрэгсэлд өгч буй сөрөг үнэлгээ нь суурь хэд хэдэн шалтгаанаас үүдэлтэй. Үүнд:

- Жижиг зах зээлд олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл зэрэгцэн оршиж буй нь цэвэр өрсөлдөөний боломжийг хумьснаар ОНМХ-үүд санхүүгийн хараат бус байдлаа зөв шийдвэрлэхэд асуудал тулгарч байна. Энэ нь улс төр, эдийн засгийн бүлэглэлүүдэд үйлчилж “амь зогоох” тактикт редакциуд шилжихэд хүргэж байна.

- Эдийн засгийн чадамжаас шалтгаалан редакци дахь нэгж сэтгүүлчийн ажлын ачаалал их, цалин хангамж бага, аюулгүй байдал, эрх зүйн хамгаалах механизм сул зэргээс үүдэн ул суурьтай, судалгаатай, хүлээн зөвшөөрөгдөх түвшний сэтгүүл зүйн контент хомсдож байна.
- Улс төрийн хүрээнийхэн хэвлэл мэдээллийн хүч, чадамжийг мэдэхгүйдээ, иргэдийн улс төрийн боловсролыг дээшлүүлэх хэрэгтэйг ухамсарлаагүйдээ бус, харин хүлээн авагч, мэдээллийг түгээгч аль аль нь “харанхуй”, мартамхай, эмх замбараагүй байх тусам тэдэнд /авлига, эрх мэдлийн сүлжээгээ хамгаалагчид/ илүү ашигтай байгаа учир хэвлэлийн нүүр, телевизийн эфирийг популизмын өрсөлдөөний талбар төдийгөөр ашиглах сонирхол давамгайлж байна.
- Нийгэм-улс төрийн процессийг илчлэн шүүмжлэх нь редакциудад эрсдэлтэй, зарлагатай, зарим тохиолдолд аюултай учир сэтгүүлчид энтертейнмент, инфотейнмент, маркетинг, PR-ын зорилгод илүү үйлчлэх болов.

Үр дүнд нь ОНМХ-ийн нийт контент дэх “цэвэр” сэтгүүл зүйн зорилго, агуулгад нийцсэн мэдээллийн эзлэх хувь багасч, улс төрийн үйл явцад зөвхөн үзэл бодол, байр суурийн өрсөлдөөнийг “зөөвөрлөн дамжуулагчийн” үүрэг гүйцэтгэж байна.

Хэдийгээр нэгж сэтгүүлч, нэгж редакцийн түвшинд тоочих асуудал олон боловч, ОНМХ-ийн бүхэл систем, сэтгүүл зүйн тогтолцооны тухайд үзвэл Монголын дүр зураг харьцангуй эерэг харагдана. Аль 1960-аад онд канадын социологч, мэдээлэл харилцааны нэрт онолч М.Маклюэн “Мэдээллийг түгээх хэрэгсэл оршин тогтнож байх нь ямар

мэдээлэл хүргэж байгаагаасаа илүү чухал³” хэмээн тэмдэглэсэн нь бий. Энэ нь Монголын ОНМХ-үүдийг тус бүрт нь авч үзвэл ёс зүй, хариуцлага, дүн шинжилгээний хувьд “но”-той ч бүхэл зургаар нь харвал олон ургальч, ардчилсан, нийгмийн бүлгүүдэд үйлчлэх шинж чанараа хадгалж байгаагаар нотлогдох мэт.

“Монголын Хэвлэлийн Хүрээлэн” ТББ-ын 2016 оны УИХ-ын сонгуулийн үеэрх хэвлэл мэдээллийн мониторингийн судалгааны дүнгээр сонгуультай холбоотой мэдээллийн 6 орчим хувь нь сонгогчийн боловсролд зориулагдсан контент байсан ба иргэдэд сонгуулийн хуулийн зүйл заалтыг тайлбарласан, сонгогчийн жагсаалтанд өөрийн мэдээлэл байгаа эсэхийг шалгах тухай гэх зэрэг лавах шинжтэй мэдээлэл зонхилж байв⁴. Үлдсэн бүх агуулга нь нам, нэр дэвшигчдийн сурталчилгаа, улс төрийн хүчнүүдийн захиалгат нийтлэл, нэвтрүүлэг эзэлжээ. Мэдээж энэ бол чамлалттай үр дүн. Өдгөө Монголын сонгогчид зүүний, эсвэл барууны чиглэлийн нам ямар бодлого баримталдаг, социал-демократ, либераль идеологийн ялгаа юунд орших тухай үл мэдэх, үл ойлгох түвшинд хүрсэн ба улс төрийн намын хувьд үзэл баримтлал бус танигдсан лидер чухал үүрэгтэй болсон байна.

Иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг төлөвшүүлнэ гэдэг нэг сонгуулийн хүрээнд, эсвэл нэг сэтгүүлч, нэг редакцийн хийх боломжтой зүйл биш гэдэг нь ойлгомжтой. Өдөр тутмын сонинуудын улс төрийн үйл явдлын нүүр дэх үйл явдлын товчоон, арилжааны телевизүүдийн мэдээллийн хөтөлбөр дэх эзэмшигчийн “өнцөг” шингэсэн байр суурийн тодруулга шинжтэй ярилцлагаар бий болохгүй нь бүр илэрхий. Ядаж 1990-ээд оны эхэнд

суурь нь зөв тавигдаж байсан намуудын үзэл баримтлалын ялгаа, түүний тухай олон нийтийн хэлэлцүүлэг өнөө үед дутагдаж байна. Иргэдийн улс төрийн боловсрол дорой байх тусам зонхилгогч намуудын хувьд ч үзэл баримтлал, бодлогын зааг ялгаа нь сарниж, мөрийн хөтөлбөр, популист амлалт, биенийхээ эсрэг “ажилладаг” тактик, олон нийтэд ханддаг арга барил яг ижил болж төлөвшчээ.

Хэдийгээр зах зээл нь хөдөлгөөн савалгаа ихтэй, технологийн нөлөөгөөр хувьсах сорилттой нүүр тулж байгаа ч уламжлалт мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн ухамсарт нөлөөлдөг, санаа бодлыг бүрдүүлдэг улс төрийн хүчтэй институт хэвээр байгаа. Сошиал медиад суурилсан мэдээллийн урсгал нь олон нийтэд хувь хүний эрх ашигт нийцсэн, заримдаа хэт туйлширсан, “сонин содон” байр суурь, тайлбарыг нийгмийн багахан хэсэгт санал болгож, тэдгээр нь хоёр хоногийн настай мэдээллийн трендийн үүрэг гүйцэтгэж байна. Зарим пост, твитийн ач холбогдол, үнэ цэнийг үгүйсгэж болохгүй ч тэдгээр нь сэтгүүл зүйтэй өрсөлдөх түвшинд очоогүй, очихгүй гэдэгт итгэлтэй байна. Энэ үзэгдлийг 19-р зуунд АНУ-д өрнөсөн олон нийтийн хэвлэлийн тэсрэлт, 1990-

ээд оны Монгол дахь шар хэвлэлийн “бүүм”-тэй зүйрлэж болно. Сошиал орчны мэдээлэлд “олноос ялгарах” гэсэн ганц зорилго давамгайлдаг. Хэвлэл мэдээлэлд тавигддаг хууль, эрхзүйн болон ёс зүйн хэм хэмжээнд нийцэх албагүй байдаг шинж нь жиргээчдийг, фэйсбүүкийн зорилтот аккаунтуудыг хурдтай, зоригтой, хүчтэй мэт “хуурмаг үзэгдлийг” бий болгодог.

Олон улсын бодлого тодорхойлогчдын зүгээс сошиал орчны зохицуулалтанд онцгой анхаарч эхэлсэн бөгөөд зарим хатуу зохицуулалт хэрэгжиж эхлээд байна. Манай улсад ч харилцаа холбооны салбарын шинэ хууль хэлэлцэгдэж байгаа энэ үед УИХ-ын гишүүн Н.Учрал 5000-аас дээш дагагчтай сошиал акаунтыг ХМХ гэж тооцох тухай санал хэлж олон нийтийн хариу үйлдлийг ажиглаж сууна. Цаад учир, зорилгыг ухамсарлаагүй жиргээчид “Би хэвлэл мэдээллийн хэрэгсэл болчихлоо” хэмээн цээжээ дэлдэцгээх болов. Угтаа бол энгийн иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөгөө нээлттэйгээр, хүртээмжтэйгээр эдлэх талбар болж буй сошиал сүлжээг хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй адилтган хуулийн этгээд болгох нь дээр дурдсан хуулийн

«

Хэдийгээр зах зээл нь хөдөлгөөн савалгаа ихтэй, технологийн нөлөөгөөр хувьсах сорилттой нүүр тулж байгаа ч уламжлалт мэдээллийн хэрэгслүүд олон нийтийн ухамсарт нөлөөлдөг, санаа бодлыг бүрдүүлдэг улс төрийн хүчтэй институт хэвээр байгаа. Сошиал медиад суурилсан мэдээллийн урсгал нь олон нийтэд хувь хүний эрх ашигт нийцсэн, заримдаа хэт туйлширсан, “сонин содон” байр суурь, тайлбарыг нийгмийн багахан хэсэгт санал болгож, тэдгээр нь хоёр хоногийн настай мэдээллийн трендийн үүрэг гүйцэтгэж байна. Зарим пост, твитийн ач холбогдол, үнэ цэнийг үгүйсгэж болохгүй ч тэдгээр нь сэтгүүл зүйтэй өрсөлдөх түвшинд очоогүй, очихгүй гэдэгт итгэлтэй байна

»

болон ёс зүйн хэм хэмжээг энгийн нэг жиргээчид тулгах үндэс л болно.

Сошиал сүлжээний хүртээмж, хүчин чадал, цаашдын хөгжлийн талаар урт удаан мэтгэлцээн өрнүүлж болох ч нэг зүйлийг хүлээн зөвшөөрөх ёстой. Тэр нь нийгмийн идэвх оролцоо сайтай, улс төрийн нийгэмшил, боловсролын түвшин өндөр иргэд сошиал ертөнцөд /наад зах нь Монголын нөхцөлд – зох./ жинтэй орон зайг эзэлж буй. Тэдэнд олон нийтийн улс төрийн болосролд хувь нэмэр оруулах боломж бий. Сошиал ертөнц дэх фейкньюс, гэмт хэрэг, гаж үйлдлийг ялгах “шүүлтүүр”-үүд технологийн шийдлээ олж хэрэглээнд нэвтрэх тусам дээр дурдсан улс төрийн идэвхтэй бүлгийн нөлөө ихэснэ.

Сэдвийн хүрээнд дүгнэн хэлэхэд, иргэдийн улс төрийн боловсролын асуудал нь улс орны хөгжлийн гарцыг сонгох, хувь хүний амьдрал, ажил үйлс, эх орны ирээдүйдээ итгэх итгэл төлөвшихөд чухал үүрэгтэй ба сэтгүүл зүйн салбараас хамаарч болох хэд хэдэн гаргалгаа бий.

- Иргэдэд төрийн субъектүүдийн эрх мэдэл, чиг үүргийн талаар цэгцтэй, бодитой мэдлэгийг редакциуд нийгмийн хариуцлагын хүрээнд цогцоор хүргэж байх хэрэгтэй. Энэ нь нэг өдөр, нэг нийтлэл, нэвтрүүлгээр шийдвэрлэгдэх зүйл биш гэдэг нь ойлгомжтой.
- Яг өнөөдөр, аль улстөрч, ямар байр суурьтай байгааг онцлох, түүнийг хүргэх нь ерөөс ОНМХ-ийн шууд үүрэг биш болсон. Ингэснээр тэдний пиар, мэдээллийн манипуляцийн хэрэгсэл болж, “ашиглуулж” байгаа л хэлбэр гэдгийг ухамсарлах. Харин улс төрийн үйл явцад “Хэн юу хэлэв?” гэсэн асуултын

түвшинд бус “Хэн яагаад ингэж хэлэв?” гэх аудиторийн асуултанд хариулахыг зорих нь зүйтэй.

- Мэргэжлийн сэтгүүл зүй нь тухайн цаг хугацаанд олны анхаарал татаж буй мэдээллийн трендэд автаж салхины аясаар “хийсэх” учиргүй. Чухал хэмээн тооцсон нийгэм, улс төрийн үйл явдалд нухацтай, нэхэл хатуутайгаар хандаж, асуудал шийдвэрлэгдтэл буюу бүрэн дүүрэн тодорхой болох хүртэл мэдээлэх, эрэл хайгуул хийх, хариуцлага шаардах нь зүйтэй юм.
- Сэтгүүлчийн, цаашлаад редакцийн хараат бус байдлыг хангах чиглэлд “гал тогоо”-ндөө зөв шийдэл олж, шударга өрсөлдөөний механизмыг санаачлан, идэвхжүүлэх шаардлага тулгарч байна.

Дүгнэлтийн оронд: ОНМХ-үүд жинхэнэ утгаараа дөрөв дэх засаглал, ардчилалын “хоточ нохой”-н үүргээ гүйцэтгэхийн тулд тодорхой нөхцөл, тохироо бүрдэхийг хүлээх нь утгагүй юм. Манай редакциуд, сэтгүүлчид иргэд, судлаачдын зүгээс шүүмж сонсохоороо олон зовлон тоочдог. Тийм ч эрх зүйн орчин дутмаг, ийм ч дарамт шахалт, тэр ч сургалтын чанар гэх мэт. Хэвлэл мэдээллийн орчинд олон хууль батлагдах тусам амьсгалах агаар, амьдрах орон зай нь багасдаг гэсэн үндэслэлээр Скандинавын улс орнуудад сэтгүүл зүйн салбарт тусгайлан үйлчилдэг эрх зүйн акт тун цөөн. Гэтэл чөлөөт хэвлэл, хүний хөгжил, ардчилалын индексээр чухам энэ бүс нутгийн улс орнууд л дэлхийд тэргүүлдэг. Шашин, улс төрийн хатуу дэглэм, диктатур үйлчилдэг Пакистан улсын сэтгүүлчид олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрэн сурвалжлах сэтгүүл зүйн шагнал хүртэж болж л байна. Энэ бүхэн нь

манай хэвлэлийн салбарын менежерүүд “амь зогоох” тактикаасаа салж, редакцийн бодлого, нийгмийн хариулага, мэргэжлийн нэр хүнд, чиг үүрэгтээ бодлоо чилээх цаг болсныг илтгэнэ.

Ишлэл

1. Болд-Эрдэнэ Б. 2017. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль 2017: Нийгмийн сүлжээ ба олон нийтийн санаа бодлын дарангуйлал// Сэтгүүл зүй МУИС-ийн ЭШБ №18. 22 дахь тал
2. <https://all-politologija.ru/knigi/politicheskaya-nauka-gadzhiev/mesto-i-rol-smi-v-politike>
3. McLuhan M. 1964. Understanding Media: The Extensions of Man. — N.Y.: McGraw Hill, P138
4. Маршалл Маклюэн. 2007. Понимание медиа: внешние расширения человека = Understanding Media: The Extensions of Man. — М.: Кучково поле, 2007. — 464 с.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2017. Нийгмийн харилцааны онол, практик. УБ.

2. Галаарид Б. 2018. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ.
3. Маклюэн М. 2007. Понимание медиа: внешние расширения человека = Understanding Media: The Extensions of Man. — М.: Кучково поле
4. Ожиганов Э.Н. 2009. Моделирование и анализ политических процессов: Учеб. по-собие. - М.: РУДН.

Резюме

Автор данной статьи затрагивает вопрос о роли и месте СМИ в политическом процессе страны, об уровне политического образования граждан Монголии в наши дни. Рассматривая сегодняшние политические события и массовые информационные процессы, автор приходит к выводу, что СМИ – это важнейшие инструменты реализации политического процесса, и в формировании политической культуры граждан и развитии институтов гражданского общества в Монголии очень важна помощь демократических средств массовой информации.